Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 16,675,699.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12,124,676.7 мянган төгрөгөөр бууруулж 4,551,022.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус байгууллага нь гэр бүл, хүүхэд, залуучууд гэсэн нийгмийн бүлгүүдэд зориулсан хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлдэг ба нийгмийн бүлгүүдээр зардал батлуулахаар Сангийн яаманд төсвийн төлөвлөлтийн санал хүргүүлдэг боловч зөвхөн хүүхэд хамгааллын зардал батлагдсан байна.

Нийгмийн бүлэгт чиглэсэн үйл ажиллагааны зардлын задаргаа

/мянган төгрөг/

№	Зардлын ангилал	2020 оны төсвийн төслийн санал	2020 онд батлагдсан	2020 оны төсвийн тодотголоор
1	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	5,411,121.7		
2	Хүүхдийн хөгжил, хамгаалал	8,044,763.7	3,500,000.0	2,222,836.9
3	Залуучуудын хөгжил, хамгаалал	1,565,000.5		
Нийт дүн		15,020,885.9	3,500,000.0	2,222,836.9

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 45 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,500,000.0 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,226,873.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 4,185.0 мянган төгрөг, нийт 3,231,058.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,996,788.9 мянган төгрөгийг зарцуулж 234,269.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,996,788.9 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 220,017.2 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,958.4 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 573.9 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 362.8 мянган, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 167.3 мянган, бусад урсгал шилжүүлэг 4.5 мянган, нийт 230,084.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Коронавирус “Ковид-19” цар тахлын дэгдэлт тархалт нэмэгдсэнээр улсын хэмжээнд онцгой нөхцөл байдал бий болж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 220,017.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагджээ. Тухайлбал:

- Хүүхдийн ордон, зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжиж, хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, хөгжих эрхийг дэмжих үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах замаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөт ажлууд дутуу хэрэгжсэнээр 275,527.8 мянган төгрөгийг зарцуулаагүй,
- Хохирогчийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн хүний нөөцийг чадавхжуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд халдвар хамгааллын хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, тасралтгүй ханган ажиллаж батлагдсан төсвөөс 64,300.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын хүүхдийн сангаас 353,966.7 мянган, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 5,050.0 мянган, нэмэлт санхүүжилтийн /НҮБ-ын хүүхдийн сан/ урьд оны зарцуулагдаагүй үлдэгдэл 155,191.1 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 15,512.4 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,032.0 мянган, нийт 535,752.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 365,721.8 мянган, нормативт зардалд 81,882.0 мянган, хангамж, бараа материалын зардалд 47,294.3 мянган, томилолт зочны зардалд 28,428.0 мянган, байр ашиглалттай холбоотой зардалд 3,200.0 мянган, нийт 526,526.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 9,226.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 442 мэдээллээс 414 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хоцроож, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 119,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн, 393,864.6 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 95.5 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Биелэлтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	119,500.0	1	119,500.0			100.0
Зөвлөмж	6	393,864.6	5	376,312.6	1	17,552.0	95.5
Нийт дүн	7	513,364.6	6	495,812.6	1	17,552.0	96.6

/мянган төгрөг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 372,958.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 236,736.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 17,552.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 85,181.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 33,487.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө дансанд анхны өртгөө бүрэн нөхсөн 89 нэр төрлийн 138,420.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тухайлбал 48 нэр төрлийн 108,310.2 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн 25,013.2 мянган төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил, 24 нэр төрлийн 3,172.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,135.0 мянган төгрөгийн санхүүгийн программ байсныг хөрөнгийн дахин үнэлгээ хийж 18,730.0 мянган төгрөгөөр бүртгэн залруулав.
2. НҮБ-ын хүүхдийн сангийн 43,335.6 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийн буцаалтыг, санхүүгийн үр дүнгийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасныг санхүүгийн үр дүнгийн тайланд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлогын дүн болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын дүнг 43,335.6 мянган төгрөгөөр бууруулж, залруулав.
3. Үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгэсэн эсэхийг нягтлан шалгахад 28,390.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 22,824.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй машин, тоног төхөөрөмж, 7,860.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 1,605.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тавилга, аж ахуйн эд хогшлыг бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 17,552.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 85,181.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл-д "Захиргааны байгууллага хохирлоо барагдуулах" 103.1-д "иргэн хуулийн этгээдийн барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухай захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж тус тус заасныг хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

2. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 3 дахь шатны шинэчлэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний 102/2020 дугаартай гэрээг 145,000.0 мянган төгрөгөөр "Бид солюшн" ХХК-тай байгуулан 72,500.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд ажлын даалгавар, тайлан гаргах хуваарийг баталж, хавсаргаагүй. Зөвлөх үйлчилгээний гэрээнд 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр программын шинэчлэлийг дуусгаж, өгөхөөр заасан ба техникийн болон бодлогын шаардлага хангагдаагүй учир хүлээн аваагүй нь Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр

тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг", Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан хугацааг баримтлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй 12,681.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам" -ын 8.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор хэрэгжүүлнэ", 8.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг уг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3. Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хугацаа хоцроож мэдээлсэн, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.4.4, 6.4.9-т заасантай нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 33,487.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дээд шатны төсөв захирагч төсвийн хуваарийг зөв хийдэггүйгээс Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамж, төлбөр зардлаас Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Дүүргийн хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, орон нутаг дахь хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсүүдэд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах хөгжлийн төвд нийт 624,368.1 мянган төгрөг шилжүүлж, зарцуулсан байна.

2020 онд нийгмийн бүлэгт зориулсан сургалтын модуль бэлтгэх, боловсруулсан арга зүйн гарын авлага, нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа, нөлөөллийн арга хэмжээний зэрэг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний файлын нэгдсэн сан бүрдүүлэх, ажил үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шатахуун зардал данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Шатахуун, тос тослох материалын зарлагын гүйлгээний анхан шатны баримт бүрдэл хангалтгүй байна. Тухайлбал 6,184.2 мянган төгрөгийн шатахууны баримтыг тайланд хавсаргаагүй, задгай хадгалсан, 3,329.6 мянган төгрөгийн зарлагын анхан шатны баримт бүрдэл хангагдаагүй байна.

2. Автомашинуудын бензин зарцуулалт, ашиглалтад тавих хяналт сул. Сар бүрийн жолоочийн тооцооны хуудасны ирсэн явсан цагийн бүртгэл байхгүй, шатахууны зарцуулалтад нягтлан бодогчийн зүгээс хяналт тавьж, тооцоог бодоогүй, зарим автомашины жолоочийн тооцооны хуудас 2020 оны хагас жилээс хойш хөтлөгдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Шатахууны зардалд бүртгэлээр тавих хяналт алдагдах, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, шатахуун зарцуулалтын тооцоог бодож байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх хөтөлбөрийн хүрээнд бэлтгэн нийлүүлж, зарцуулсан 18,960.0 мянган төгрөгийн сургалтын материал, хэрэгслийг бараа материалын дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Журам батлах тухай /Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар/-ын Бараа материалын бүртгэл 4.21-д "Бараа материалыг /хангамжийн зүйлийг/ худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал, Кт. Мөнгөн хөрөнгө /Дансны өглөг/, (г). Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгохдоо: Дт. Зардал /Зардлын зүйлээр/, Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Бараа материалд бүртгэлээр тавих хяналт алдагдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Хүлээн авсан бараа материалыг дансанд бүртгэж, хэвших

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөтөлбөрөөр орон нутагт томилолтоор ажиллахдаа байгууллагын албан ажлын автомашиныг ашиглалгүй,

автомашин түрээсэлж 2,750.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан Төсвийн тухай хуулийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Зардалд бүртгэлээр тавих хяналт алдагдах, үргүй зардал гарах

3.3. Өгсөн зөвлөмж:

Томилолтоор ажиллахдаа байгууллагын автомашиныг ашиглах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4 Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын үйлчилгээний хөлснөөс 525.0 мянган төгрөгийн татвар суутгаагүй, 1,739.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т "Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна: 1/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн", Татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараах орлогод албан татвар ногдуулна" 8.1.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалт болон Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр "Зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын холбогдох заалттай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүйгээс үүсэх торгууль, алданги төлөх

4.3. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг цаг хугацаанд төлөх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

5 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын зохион байгуулалтын бүтцийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн А/90 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт-д "харьяа байгууллагуудаар Сургалт, судалгаа мэдээллийн төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах, байр, Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, "Өнөр бүл" хүүхдийн төв, салбар байгууллагаар аймгийн /21/, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс" гэж баталсан байна. Харьяа байгууллагуудын төсөв төсвийн шууд захирагч бүрээр батлагдаж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан шууд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд нэгтгэгдэн тайлагнаж байгаа нь агентлагийн үүрэг хариуцлагыг алдагдуулж байна. Мөн Сургалт, судалгаа мэдээллийн төв 2020 онд 102,567.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба 80,691.6 мянган төгрөгийн цалин хөлс нь тус газраас олгогдсон бөгөөд санхүүгийн тайлан гаргадаггүй харьяа байгууллага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн эхний тайлангийн жил нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн А/90 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт-д "харьяа байгууллагуудаар Сургалт, судалгаа мэдээллийн төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах, байр, Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолбор, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, "Өнөр бүл" хүүхдийн төв, салбар байгууллагаар аймгийн /21/ ,нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Эрсдэл:

Агентлагийн үүрэг хариуцлагыг алдагдуулах, санхүүгийн тайлан гаргахгүй байх

5.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын төсвийг тус газрын төсөвт батлуулан, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэх

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын нэр:	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит			
Огноо:	2020 он	Аудитын код:	САГ-2021/101/СТА-ТШЗ	Мянган төгрөг
Шалгагдсан байгууллагын нэр:	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар			

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	17,552.0	Төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
2	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 3 дахь шатны шинэчлэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний 102/2020 дугаартай гэрээг 145,000.0 мянган төгрөгөөр "Бид солюшн" ХХК-тай байгуулан 72,500.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан хугацааг баримтлаагүй байна.	72,500.0	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
3	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй үндсэн хөрөнгө акталсан.	12,681.8	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
4	Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 442 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож, нэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй,	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
5	Шатахуун, тос тослох материалын зарлагын гүйлгээний анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, автомашинуудын бензин зарцуулалт, ашиглалтад тавих хяналт сул. Сар бүрийн жолоочийн тооцооны хуудасны ирсэн явсан цагийн бүртгэл байхгүй, шатахууны зарцуулалтад нягтлан бодогчийн зүгээс хяналт тавьж, тооцоог бодоогүй, зарим автомашины жолоочийн тооцооны хуудас 2020 оны хагас жилээс хойш хөтлөгдөөгүй	9,513.8	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
6	Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх хөтөлбөрийн хүрээнд бэлтгэн нийлүүлж, зарцуулсан сургалтын материал, хэрэгслийг бараа материалын дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэж тайлагнасан байна.	18,960.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
7	Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөтөлбөрөөр орон нутагт томилолтоор ажиллахдаа байгууллагын албан ажлын автомашиныг ашиглалгүй, автомашин түрээсэлж үргүй зардал гаргасан.	2,750.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
8	Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын үйлчилгээний хөлснөөс татвар, нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй	2,264.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
9	Харьяа байгууллагуудын төсөв төсвийн шууд захирагч бүрээр батлагдаж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан шууд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд нэгтгэгдэн тайлагнаж байгаа нь агентлагийн үүрэг хариуцлагыг алдагдуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/90 дугаар тушаалын хэрэгжилт хангалтгүй байна.	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Энх-Амар Б.Наранцацрал
ДҮН		136,221.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 29 /АД160060

Улаанбаатар хот

САГ-2021/101/СА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн нэр бүхий 2 ажилтанд ажилгүй байсан хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн нөхөн олговрыг тухайн байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "иргэн хуулийн этгээдийн барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон 2 ажилтанд олгосон 17,552,000.00 /Арван долоон сая таван зуун тавин хоёр мянган/ төгрөгийн төр учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх, арга хэмжээ авч, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, Ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 107/А0160060
САГ-2021/101/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 3 дахь шатны шинэчлэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний 102/2020 дугаартай гэрээг "Бид солюшн" ХХК-тай байгуулан 72,500.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Тус гэрээнд 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр программын шинэчлэлийг дуусгаж, өгөхөөр заасан ба гэрээний үүрэг биелэгдээгүй, ажлын даалгавар, тайлан гаргах хуваарийг баталж, хавсаргаагүй, техникийн болон бодлогын шаардлага тус тус хангагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг", Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан хугацааг баримтлаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийг хангуулж, гүйцэтгэлийг актаар баталгаажуулж, хөрөнгийг бүртгэн, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, Ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 106/А0160060

Улаанбаатар хот

САГ-2021/101/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр 12,681.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам" -ын 8.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор хэрэгжүүлнэ", 8.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг уг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг үндэслэн данс бүртгэлээс хасч, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, Ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 105 /АД160060
САГ-2021/101/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 442 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож, нэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.7-д "Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, ахлах нягтлан бодогч Б.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Д.ЦЭРЭНДОРЖ